

МЭДЭЭЛЭЛ

Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд Улаанбаатар–Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын Багц 1–3 буюу Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто замын трассын Км31+500–Км31+700 хооронд үүссэн 200 метр урт дагуу хагарлыг засварлах ажил хийгдэнэ.

Уг ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан төслийн замын хэсэг болох А0401 дугаартай улсын чанартай авто замын Бороогийн (Хоёрын) давааны Км132+490–Км134+186 хоорондох 1.72 км авто замыг 2026 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл түр хугацаагаар хааж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг доорх маршрутын дагуу түр замаар зохион байгуулахаар холбогдох шийдвэрийг гаргалаа.

Иймд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр замаар зохион байгуулах хугацаанд жолооч та бүхэн замын хөдөлгөөний дүрмийг чанд мөрдөж, хурдаа тохируулан, анхаарал болгоомжтой зорчино уу.

Улаанбаатар–Дархан чиглэлийн авто замын түр хаагдах хэсэг болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохион байгуулах түр замын маршрут

№	Үндсэн замын чиглэл	Хаах хэсэг	Хаах хэсгийн урт /км/	Тээврийн хэрэгсэл зорчих түр маршрут /км/
1	Багц 1-3 хэсэг буюу Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто зам	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын нутаг дэвсгэрт байрлах Бороогийн давааны ар хэсэг	УБ-Дархан чиглэлийн замын трассын /Км132+490-Км134+186/ буюу Багц 1-3 хэсгийн замын трассын /Км30+800-Км32+526/ хооронд 1.72 км	Бороогийн давааны орой дээр /Км30+800/-ээс давааны ар хормой /Км32+526/ хүртэлх авто замын баруун гар талаар 1.86 км түр зам

